

## ГАРЧИГ

|                                                                                                                                                      |    |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| <i>НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i> .....                                                                                         | 3  |
| 1.1. Төслийн ерөнхий мэдээлэл .....                                                                                                                  | 3  |
| 1.2. Уурхайн ажиллах горим. ....                                                                                                                     | 4  |
| 1.3. Ашиглалтын систем.....                                                                                                                          | 4  |
| 1.4. Өрөмдлөг тэсэлгээний ажил .....                                                                                                                 | 5  |
| 1.5. Уурхайн тээвэр .....                                                                                                                            | 6  |
| 1.6. Овоолгын аж ахуй.....                                                                                                                           | 6  |
| 1.7. Баяжуулах үйлдвэр .....                                                                                                                         | 7  |
| 1.8. Цахилгаан, дулаан, усан хангамж .....                                                                                                           | 7  |
| 1.9. Уурхайн бүтэц бүрэлдэхүүн.....                                                                                                                  | 7  |
| 1.10. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө.....                                                                                                      | 9  |
| <i>ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-<br/>ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА</i> .....                          | 10 |
| <i>ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН<br/>БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ</i> .....                                                | 11 |
| <i>ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН<br/>ТӨЛӨВЛӨГӨӨ</i> .....                                                                   | 15 |
| 4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....                                                                                       | 16 |
| 4.2. Уурхайн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....                                                                                                       | 18 |
| 4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....                                                                   | 18 |
| 4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....                                                                           | 18 |
| 4.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....                                                                                     | 19 |
| 4.6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө.....                                                                                                    | 19 |
| 4.7. Хог, хаягдлын менежментийн арга хэмжээний зардал .....                                                                                          | 20 |
| 4.8. Тухайн жилийн орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр .....                                                                                          | 21 |
| 4.9. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө.....                                                                                      | 22 |
| 4.10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд<br>өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь ..... | 22 |

## ХҮСНЭГТИЙН ГАРЧИГ

|                                                                                                                                  |    |
|----------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим.....                                                                                            | 4  |
| Хүснэгт 2. Ашиглалтын системийн элемент.....                                                                                     | 5  |
| Хүснэгт 3. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд.....                                                                                     | 5  |
| Хүснэгт 4. Тэсэлгээний аюулгүйн зай тооцоо.....                                                                                  | 6  |
| Хүснэгт 5. Тэсэлгээний материал, хэрэгслийн жилийн хэрэгцээ.....                                                                 | 6  |
| Хүснэгт 6. Ачааны автомашины техникийн үзүүлэлтүүд .....                                                                         | 6  |
| Хүснэгт 7. Ангилан ялгах хэсгийн ажиллах хүчний тооцоо .....                                                                     | 9  |
| Хүснэгт 8. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь<br>нөлөөллийн төрөлтэй уялдах нь..... | 11 |
| Хүснэгт 9. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь<br>нөлөөллийн төрөлтэй уялдах нь..... | 13 |
| Хүснэгт 10. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардал.....                                                                | 16 |
| Хүснэгт 11. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....                                                                                    | 18 |
| Хүснэгт 12. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....                                                                  | 18 |
| Хүснэгт 13. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө .....                                               | 18 |
| Хүснэгт 14. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө .....                                                         | 19 |
| Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө .....                                                                        | 19 |
| Хүснэгт 16. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө .....                                                                           | 20 |
| Хүснэгт 17. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....                                                                              | 21 |
| Хүснэгт 18. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөө .....                                                          | 22 |
| Хүснэгт 19. Төслийн төлөвлөлт, биелэлтийг тайлагнах хуваарь .....                                                                | 22 |

## ЗҮРГИЙН ГАРЧИГ

|                                              |   |
|----------------------------------------------|---|
| Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байриил..... | 3 |
|----------------------------------------------|---|

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ТӨСЛИЙН ТУХАЙ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1.Төслийн ерөнхий мэдээлэл

**Төслийн нэр:** “Асгат-Уул” нэртэй шохойн чулууны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл

**Төсөл хэрэгжүүлэгч:** “СИ БИ ЗИ” ХХК. Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 6-р баг, 65-р байр-өөрийн байр. Утас: 9905-3180

**Төсөл хэрэгжүүлэх талбайн байршил:** Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутаг, “Силикат” ХХК-ны төв байрнаас зүүн хойд зүгт 10 км зайд дэд бүтэц зам харилцаа сайн хөгжсөн дүүрэгт оршдог.

Талбайн солбицлууд:


- |    |                |                 |
|----|----------------|-----------------|
| 1. | 49° 27' 01.93" | 106° 03' 11.24" |
| 2. | 49° 27' 01.93" | 106° 02' 41.23" |
| 3. | 49° 27' 16.93" | 106° 02' 41.23" |
| 4. | 49° 27' 16.93" | 106° 03' 11.24" |

**Төсөл хэрэгжүүлэгч** Улсын бүртгэлийн гэрчилгээ

|                                                                   |                            |            |
|-------------------------------------------------------------------|----------------------------|------------|
| <b>байгууллагын хууль эрх зүйн хүчинтэй баримтуудын жагсаалт:</b> | ✓ Улсын бүртгэлийн дугаар: | 1911013037 |
|                                                                   | ✓ Регистрийн дугаар:       | 2076624    |
|                                                                   | ✓ Улсад бүртгүүлсэн:       | 2010.06.24 |

Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл

|                  |            |
|------------------|------------|
| ✓ Дугаар:        | MV-007746  |
| ✓ Олгосон огноо: | 2007.01.29 |



Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн байршил

## 1.2. Уурхайн ажиллах горим.

Уурхайн ажиллах горимыг уурхайн жилийн хүчин чадалтай нь уялдуулан дараах байдлаар сонгов.

Уурхай нь жилд 47100 тн шохойн чулуу олборлоно. Иймд шохойн чулуу олборлолтын ажлыг улирлын чанартай гүйцэтгэхээр тооцоолов. Уурхайн ажиллах горим нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ.

**УУРХАЙ НЬ: ХӨРС ХУУЛАЛТ ► ӨРӨМДЛӨГ ТЭСЭЛГЭЭ ► ШОХОЙН ЧУЛУУ ОЛБОРЛОЛТ ► БЭЛЭН БҮТЭЭГДЭХҮҮНИЙГ ХЭРЭГЛЭГЧДЭД АЧИЖ НИЙЛҮҮЛЭХ** гэсэн технологийн үндсэн горимын дагуу ажиллана.

Уурхай нь жил бүрийн 4 дугаар сарын 01-нээс 10 дугаар сар дуустал шохойн чулуу олборлох ажил явагдах бөгөөд уулын ажил бусад үйл ажиллагаа нь /техник, тоног төхөөрөмж/ дараах байдлаар явагдана:

Хүснэгт 1. Уурхайн ажиллах горим

| №  | Үндсэн ажиллагаа                             | Хэмжих нэгж | Үзүүлэлт       |
|----|----------------------------------------------|-------------|----------------|
| 1  | Үйлдвэрлэлийн бэлтгэл ажил                   | Хоног       | 15 (4.01-4.15) |
| 2  | Шохойн чулуу олборлон боловсруулах ажиллагаа | Сар         | 6 (4.15-10.31) |
| 3  | Хуанлийн өдөр                                | Хоног       | 214            |
| 4  | Амралтын өдөр                                | Хоног       | 60             |
| 5  | Цаг агаарын хүндрэл                          | Хоног       | 14             |
| 6  | Засвар үйлчилгээ                             | Хоног       | 10             |
| 7  | Жилд ажиллах хоног                           | Хоног       | 130            |
| 8  | Жилд ажиллах цаг                             | Цаг         | 1040           |
| 9  | Хоногт ажиллах ээлж                          | Ээлж        | 1              |
| 10 | Ээлжийн үргэлжлэх хугацаа                    | Цаг         | 8              |
| 11 | Цаг ашиглалтын коэффициент                   | -           | 0.85           |
| 12 | Жилд ажиллах цэвэр цаг                       | Цаг         | 884            |

Энд ажлын үргэлжлэх хугацаанд тохиолдох албан ёсны амралт, баяр ёслолын өдрүүдийг тооцон хөрс хуулалтын ажил, олборлолт ажиллах хугацаа 130 өдөр гэж тооцоолсон болно.

## 1.3. Ашиглалтын систем

**Ашиглалтын системийн сонголт:** Ордын хэмжээнд хуулах хөрсний хэмжээ бага, дундаж хэмжээ нь 1-2м байх бөгөөд үүнээс шимт хөрсний зузаан нь 0.2 м болно.

Хөрс, ашигт малтмалын харьцаа, уурхайн сонгосон параметруудаар байгуулсан загварын дагуу хөрс хуулалтын дундаж коэффициент нь ТЭЗҮ-д тусгаснаар үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор  $0.24 \text{ м}^3/\text{тн}$  ба эхний 10 жилийн ашиглалтаар  $0.27 \text{ м}^3/\text{тн}$  байна.

Асгат уулын шохойн чулууны ордын ашигт малтмалын бат бэхийн коэффициент  $f=7$ , нягт нь  $2.5 \text{ тн}/\text{м}^3$ . Иймд өрөмдлөг тэсэлгээтэй, экскаватор, автосамосвалын хослол бүхий гадаад тээвэртэй ашиглалтын систем сонгож авлаа.

Ашиглалтын явцад хоосон чулуулгийг гадаад овоолгодбуулгах бөгөөд уг овоолгыг уурхайн хүрээний гадна, ашиглалтын лицензийн хүрээн дотор байгуулна. Цаашид уурхай гүнзгийрэх тул дотоод овоолго хийх боломжгүй.

*Ашиглалтын системийн элементүүд:* Уурхайн хүчин чадал, ажиллах тоног төхөөрөмжийн техникийн үзүүлэлтүүд, ажлын горим зэргээс хамааруулж ашиглалтын системийн элементүүдийг дараах байдлаар тооцоолон сонгов.

*Хүснэгт 2. Ашиглалтын системийн элемент*

| № | Үндсэн хэмжигдэхүүнүүд                                                                       | Хэмжих нэгж | Тоон үзүүлэлт |
|---|----------------------------------------------------------------------------------------------|-------------|---------------|
| 1 | Шохойн чулуу олборлолтын ажлын доголын өндөр                                                 | м           | 5             |
| 2 | Хөрс хуулалтын ажлын доголын өндөр:<br>өнгөн хөрс хуулалтын үед<br>үндсэн хөрс хуулалтын үед | м<br>м      | 0.2<br>1-2    |
| 3 | Шохойн чулуу олборлолтын ажлын доголын налуугийн өнцөг                                       | Град        | 65            |
| 4 | Хөрс хуулалтын ажлын доголын налуугийн өнцөг: ажлын                                          | Град        | 65            |
| 5 | Экскаваторын орлын өргөн                                                                     | м           | 13            |
| 6 | Экскаваторын ажлын фронтын урт                                                               | м           | 23            |
| 7 | Авто замын налуу                                                                             | %           | 80            |
| 8 | Авто замын өргөн                                                                             | м           | 6             |
| 9 | Ажлын талбайн өргөн                                                                          | м           | 20            |

*Ил уурхайн үндсэн хэмжээсүүд:* Хүдрийн биет, ордын уул техникийн үндсэн нөхцөл зэргийг харгалзан байгуулсан ил уурхайн үндсэн хэмжээсүүдийг тодорхойлон дараах хүснэгтэнд харуулав.

*Хүснэгт 3. Ил уурхайн үндсэн хэмжээсүүд*

| Үзүүлэлт                                | Хэмжих нэгж | Тоо хэмжээ         |
|-----------------------------------------|-------------|--------------------|
| Ил уурхайн гүн                          | м           | 884м түвшин хүртэл |
| Ил уурхайн хажуу ханын өнцөг            | градус      | 65                 |
| Хөрс хуулалтын доголын өндөр            | м           | 1.5                |
| Хүдэр олборлолтын доголын өндөр         | м           | 5-8                |
| Мөргөцгийн налуугийн өндөр              | градус      | 65                 |
| Ажлын бус доголын аюулгүй бермийн өргөн | м           | 2                  |
| Ил уурхайн жилийн хүчин чадал           | Мян/тн      | 41.1               |
| Хоногийн / ээлжийн хүчин чадал          | тн          | 411/411            |

Дээрхи авсан хэмжигдэхүүнүүдийг тусгасан дэвсгэр болон босоо, хөндлөн зүсэлт зургууд дээр ил уурхайг байгуулж ил уурхайн хил хязгаар дотор уулын цул, хүдэр болон хөрс хуулалтын хэмжээг тодорхойлов.

Хөрсний доголын налууг чулуулгийн физик механик шинж чанар, доголын өндрөөс хамааруулан уурхайн хажуу ханад 65° байхаар сонгов.

#### **1.4.Өрөмдлөг тэсэлгээний ажил**

Өрөмдлөг тэсэлгээний ажлыг тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий сервис компанитай байгуулсан гэрээний дагуу гүйцэтгүүлнэ.

*Тэсэлгээний ажлын үеийн аюулгүйн бүсийн тооцоо*

Тэсэлгээний ажлын аюулгүйн зайг дараах 4 нөхцөлөөр тооцно.

- ✓ Тэсрэлтээр шидэгдэх аюулгүй бүсийн зай
- ✓ Чичирхийллийн үйлчилгээний аюулгүй бүсийн зай
- ✓ Агаарын цохих долгионы аюулгүй бүсийн зай
- ✓ Тэсрэлтээр үүсэх хий, тоосны тархалтын бүсийн зай

Хүснэгт 4. Тэсэлгээний аюулгүйн зай тооцоо

| № | Аюулгүй бүсийн зай                                               | Нэгж | Зай |
|---|------------------------------------------------------------------|------|-----|
| 1 | Чулуулаг шидэгдэх аюулгүй бүсийн зай /ажиллагсад/                | м    | 400 |
| 2 | Чулуулаг шидэгдэх аюулгүй бүсийн зай / машин механизмд/          | м    | 200 |
| 3 | Чиирхийллийн үйлчилгээний аюулгүй бүсийн зай                     | м    | 200 |
| 4 | Агаарын цохих долгионы аюулгүй бүсийн зай /ажиллагсад/           | м    | 500 |
| 5 | Агаарын цохих долгионы аюулгүй бүсийн зай /барилга байгууламжид/ | м    | 400 |
| 6 | Тэсрэлтээр үүсэх хийн тоосны тархалтын бүсийн зай                | м    | 600 |

Хүснэгт 5. Тэсэлгээний материал, хэрэгслийн жилийн хэрэгцээ

| № | Үзүүлэлт                            | Хэмжих нэгж | Тоон утга |
|---|-------------------------------------|-------------|-----------|
| 1 | Жилд хэрэглэх тэсрэх бодисын хэмжээ | тонн        | 10.4      |
| 3 | Цочир дамжуулах шижим /ДША/         | мян.м       | 3000      |
| 4 | Тэслүүр /КД/                        | ш           | 30        |
| 5 | Удаашруулагч /КЗДШ/-/РП/            | ш           | 20        |
| 6 | Гал дамжуулах шижим /ОША/           | м           | 50        |
| 7 | Өдөөгч                              | ш           |           |

### 1.5. Уурхайн тээвэр

Тээврийн тоног төхөөрөмжийг экскавацийн төхөөрөмжинд уялдуулан сонгодог. Уурхайн уулын ажлын хэмжээ бага зэргийг харгалзан үзэж 10 тн –ийн даацтай ачааны авто машиныг сонгов.

Иймд манай улсын зах зээлд олдоц сайтай БНХАУ-д үйлдвэрлэсэн Yui Jing ачааны авто машиныг сонгон бүтээлийн тооцоог хийж гүйцэтгэлээ.

Хүснэгт 6. Ачааны автомашины техникийн үзүүлэлтүүд

| № | Үзүүлэлтүүд          | Хэмжих нэгж | Тоон утга      |
|---|----------------------|-------------|----------------|
| 1 | Загвар               |             | Yui Jing       |
| 2 | Дугуйны томьёо       |             | 4x2            |
| 3 | Даац                 | тн          | 10             |
| 4 | Тэшний эзэлхүүн      | м3          | 6              |
| 5 | Хөдөлгөөний тах хурд | Км/ц        | 55             |
| 6 | Хөдөлгүүрийн чадал   | М.х         | 266            |
| 7 | Их биенийн хэмжээс   | мм          | 8127x2496x3150 |
| 8 | Шатахуун зарцуулалт  | 100км       | 25             |

Уурхайн гадаад тээвэр:

“Си Би Зи” ХХК нь шохойн чулуугаа уурхайн аман дээрээс борлуулах бөгөөд мөн “Силикат” ХК нь хүдрийг өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэж авч явах юм.

### 1.6. Овоолгын аж ахуй

Овоолгын талбайн байриил: Асгат уулын шохойн чулууны ордын уулын ажил нийт талбайн хэмжээгээр өрнөх тул тээвэргүй ашиглалтын систем хэрэглэх боломжгүй, өөрөөр хэлбэл дотоод овоолго байгуулах нөхцөл бүрэлдэхгүй буюу ашиглагдсан хоосон орон зайнд байнга уулын ажил явагдана. Иймээс хөрс хуулалтанд тээвэртэй ашиглалтын систем хэрэглэх бөгөөд хөрсийг гадаад овоолгод буулгана.

Хөрсний овоолгыг уурхайн баруун хойд талд, газрын гадаргын хамгийн нам дор газар байгуулах нь хамгийн оновчтой хувилбар болно.

Овоолгын үндсэн параметрууд: Хөрсний хэмжээ ойролцоогоор 375,600.0 м<sup>3</sup>(20% сийрэгжинэ гэж үзэв) болно. овоолгын талбай 1.5 га газар эзэлнэ.

Овоолго байгуулах талбай нь налуу хонхор газар юм. Овоолгын ерөнхий налуугийн өнцгөөс хамааруулан 32° байхаар тооцсон болно.

### **1.7.Баяжуулах үйлдвэр**

“Си Би Зи” ХХК нь шохойн чулуугаа уурхайн аман дээрээс “Силикат” ХК-д борлуулах бөгөөд боловсруулах болон баяжуулах үйл ажиллагаа явуулахгүй болно.

### **1.8.Цахилгаан, дулаан, усан хангамж**

#### **Цахилгаан хангамж**

Ил уурхайн хувьд цахилгааны тэжээлээр ажиллах уулын үндсэн тоног төхөөрөмжөөс ганцхан өрмийн машин байх бөгөөд бусад нь бүгд дизель хөдөлгүүрээр ажиллана. Үүнээс гадна уурхайн тосгон, засварын хэсэг зэрэг хэрэглэгчид 0.4 кВ-ын цахилгаан эрчим хүчээр хангагдана.

Уурхайн цахилгаан хангамжийг 110/6 кВ-ын Бурхант дэд станцын яч№10-ын “Мөнх болор эрдэнэ” ХХК-ийн эзэмшлийн агаарын шугамын 3-р тулгуураас салбарлуулан 0.3 км агаарын шугам, 400 кВА 6/0.4 кВ-ын дэд станц барьж байгуулан шийдвэрлэсэн байна.

#### **Усан хангамж**

Уурхай нь технологийн усны хэрэгцээ байхгүй бөгөөд ахуйн хэрэгцээний усыг “Силикат” ХХК-ын гүний худгаас зөөврөөр хангана. Нэг хүний хоногийн хэрэгцээний усыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын 2015 оны 07-р сарын 30-ны өдрийн А/301 дугаар тушаалыг үндэслэн 45 л-ээр, зам талбай услах тоос дарах ажилд 7 хоногт 3 удаа /нэг удаагийн усалгаагаар 2тн/ гэж тооцлоо.

#### **Дулаан хангамж**

Уурхайн жилийн ажлын үргэлжлэх хугацаа дулааны улиралд 130 хоног тул захиргаа аж ахуйн байр, ажилчдын амрах байр зэргийг шаардлагатай үед ердийн галлагаагаар дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

### **1.9.Уурхайн бүтэц бүрэлдэхүүн**

#### **Уурхайн бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалт**

Ил аргаар шохойн чулуу олборлох “Асгат-Уул” уурхай нь хүчин чадлын хувьд бага, ажиллах хугацаа нь улирлын чанартай, Дархан хоттой ойр орших учир ажилчид бүгд байрлаж ажиллах шаардлагагүй юм. Одоогийн байдлаар уурхай дээр харуулын байр, захиргаа аж ахуйн байр, цайны газар зэргийг гэр болон тусгай тохижуулсан контейнер ашиглан барьж байгуулсан байна. Харин халуун усны байр, ажилчдын амрах байр, засварын газар зэргийг нэмж барьж байгуулахаар төлөвлөлөө.

Уурхайн бүрэлдэхүүнд:

- ✓ Хөрс хуулах, шохойн чулуу олборлох ил уурхай, хөрсний овоолго
- ✓ Шохойн чулуу бутлах, ангилан ялгах төхөөрөмж түүний дэргэдэх түр овоолго
- ✓ Захиргаа, үйлчилгээний байрууд
- ✓ Цахилгаан хангамж / цахилгаан станц /
- ✓ Засварын газар /токарь/
- ✓ Хоолны газар /Вагончик/
- ✓ Материалын агуулах
- ✓ Уурхай орчмын замууд (уурхайн эзэмшлийн талбайн хүрээнд орших) зэрэг объектууд багтана.

### ***Ил уурхай***

Уурхайн талбайг ашиглалтанд бэлтгэх ажлууд (зам байгуулах, засах г.м) өрөмдлөг тэсэлгээ, хөрс хуулах, дайрга олборлох болон хөрсний овоолго байгуулах зэрэг ажлууд явагдана.

Компаний нийт эзэмшлийн талбайн хүрээнд хүдэр ангилан ялгах, боловсруулах болон бусад туслах объектууд бүгд байршина.

Ил уурхайн бүрэлдэхүүнд:

- ✓ Хөрс хуулалт хийн шохойн чулуу олборлох уурхай
- ✓ Хөрсний овоолго
- ✓ Шимт хөрсний овоолго
- ✓ Уурхайн дотоод зам
- ✓ Өрөмдлөг тэсэлгээний ажилтай холбоотой ажилбарууд хамаарагдана.

Уурхайг ашиглаж дууссан тохиолдолд уурхайн хүрээг тойруулан тусгай төслийн дагуу хамгаалалтын далан байгуулж, анхааруулах тэмдэг байрлуулах ба бусад холбогдох арга хэмжээг авна. Энэ нь ашиглалт дуусах үед төлөвлөсөн нэмэлт зардлаар шийдэгдэнэ.

### ***Захиргаа үйлчилгээний газар***

Захиргаа үйлчилгээний объектуудад уурхайн удирдлагуудын контор (ажлын өрөө), наряд - даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, амрах, усанд орох байр зэрэг газрууд орно.

Эдгээр байгууламжуудыг өрөмдлөг тэсэлгээний ажлын аюулгүйн зөвшөөрөгдсөн бүсийн гадна барьж байгуулна.

### ***Уурхайн засвар техникийн үйлчилгээ ба агуулахын аж ахуй***

Уурхайн техник тоног төхөөрөмж, цахилгаан багаж төхөөрөмж зэргийг засварлах, хэвийн ажиллагааг хангах зорилгоор засварын газар байгуулна. Засварын газрыг дараах төхөөрөмжүүдээр тоноглоно:

- ✓ Токарь, өрмийн цахилгаан машин
- ✓ Өргөх төхөөрөмж, слесарийн бусад багажууд
- ✓ Гагнуурын зориулалтын талбай бусад багажууд

Эдгээр төхөөрөмжүүдийг засварын газарт байрлуулах бөгөөд дэргэд нь автомашин, бульдозер, утгуурт ачигч зэргийн засвар хийх боломжтой зориулалтын зарим тоног төхөөрөмжөөр тоноглогсон задгай талбай байгуулна. Сэлбэг хэрэгсэл, тоног төхөөрөмжийн түр агуулахыг 5-10 тн-ийн багтаамжтай контейнер ашиглан байгуулна. Том хэмжээний тоног төхөөрөмж, машин механизмд зориулж, саравч бүхий задгай агуулах байгуулна.

Уурхай нь Дархан хотод ойр байрлах учир шатах тослох материалын агуулах шаардлагагүй 2.5 тн багтаамжтай түлшний машинаар үндсэн тоног төхөөрөмжүүдийн түлшний хэрэгцээг хангана.

### Удирдлага зохион байгуулалт

Уурхай нь өдрийн 8 цагаар, нэг ээлжээр ажиллана. Ангилан ялгах хэсгийн ажиллах хүчний тооцоог дараах хүснэгтэд харууллаа.

Хүснэгт 7. Ангилан ялгах хэсгийн ажиллах хүчний тооцоо

| №                                        | Ажиллах хүч                         | Уурхайд ажиллах орон тоо |
|------------------------------------------|-------------------------------------|--------------------------|
| <b>Уурхайн инженер техникийн ажилчин</b> |                                     | <b>5</b>                 |
| 1                                        | Уурхайн дарга                       | 1                        |
| 2                                        | Ерөнхий инженер                     | 1                        |
| 3                                        | Уулын инженер                       | 1                        |
| 4                                        | Хөдөлмөрийн аюулгүй байдлын инженер | 1                        |
| 5                                        | Байгаль орчны мэргэжилтэн           | 1                        |
| <b>Ил уурхайн ажилчид</b>                |                                     | <b>4</b>                 |
| 2                                        | Утгуурт ачигч оператор              | 1                        |
| 3                                        | Экскаваторын оператор               | 1                        |
| 5                                        | Автосамосваллын оператор            | 2                        |
| <b>Ангилан ялгах хэсгийн ажилчид</b>     |                                     | <b>3</b>                 |
| 1                                        | Ангилан ялгах оператор              | 1                        |
| 2                                        | Гагнуурчин, засварчин               | 1                        |
| 3                                        | Цахилгаанчин                        | 1                        |
| <b>Захиргаа аж ахуйн ажилчид</b>         |                                     | <b>9</b>                 |
| 1                                        | Нягтлан                             | 1                        |
| 4                                        | Ахлах тогооч                        | 1                        |
| 5                                        | Туслах тогооч                       | 1                        |
| 6                                        | Туслах ажилчин                      | 1                        |
| 7                                        | Жолооч                              | 3                        |
| 8                                        | Харуул                              | 2                        |
| <b>Нийт</b>                              |                                     | <b>21</b>                |

#### 1.10. Тухайн жилийн уулын ажлын төлөвлөгөө

##### 2025 онд явагдах уулын ажил

Уурхайн олборлолтын үйл ажиллагааг 2025 онд ордоос 4.73 мян.м<sup>3</sup> хөрс хуулж, 47.1 мян.тн шохойн чулуу олборлож, 40.0 мян.тн бүтээгдэхүүн гаргахаар төлөвлөж байна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨСӨЛ ХЭРЭГЖИХ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### Физик газар зүй, байршил

Орд газар нь засаг захиргааны хувьд Дархан-Уул аймгийн Дархан сумын үйлдвэрийн районд байрлах “Силикат” ХХК-ны төв байрнаас зүүн хойд зүгт 10 км зайд дэд бүтэц зам харилцаа сайн хөгжсөн дүүрэгт оршдог.

Асгат уулын шохойн чулууны орд нь газар зүйн мужлалын хувьд Хангай Хэнтийн уулархаг системийн уулс хоорондох завсрын нам дор газарт байрладаг.

Нутгийн хамгийн өндөр цэг нь далайн түвшингээс дээш 800-1214м, харьцангуй өндөршил 200- 400м-т хэлбэлзэх бөгөөд Загт-Өндөр уул - 1007м, Баянтхан уул - 1021 м, Бууралт уул - 1007м, хамгийн нам дор газар нь Хараа гол юм. Түүний өндөржилт нь далайн түвшинээс дээш 694-700м өргөгдсөн байна.

Хараа гол нь хамгийн өргөн хэсэгтээ 20-25м, дундаж гүн нь 0.8-2.0 м, урсгалын дундаж хурд 0.7м/сек байна. Хур бороо элбэгтэй үед Хараа голын усны түвшин 1.0м хүртэл нэмэгдэнэ.

### Уур амьсгалын хувьд

Асгат уулын шохойн чулууны орд нь байгаль цаг уурын хувьд хоногийн температурын хэлбэлзэл ихтэй эх газрын эрс тэс уур амьсгалтай бүс нутагт багтдаг.

Зуны улиралд чийглэг уур амьсгалтай. Жилдээ дунджаар 270мм хур тунадас унадаг бөгөөд түүний 70% нь дулааны улиралд хамаарна. Зуны улиралд агаарын хамгийн их температур +30°C, цаг уурын өөрчлөлттэй үед +40°C, хааяа +45°C хүрдэг.

Өвлийн улиралд хүйтэн, хуурай уур амьсгалтай. Хүйтний улиралд агаарыг температур нь -35°C- 42°C хүфтэл буурна. Цаг уурын өөрчлөлттэй холбогдон зарим үед -45°C хүрдэг. Өвлийн улиралд жилийн хур тунадасны 30% нь унадаг. Хөрсний хөлдөлт 2.5-3.0м гүнд хүрдэг.

### Эдийн засгийн байдал

Асгат уулын шохойн чулууны орд нь Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт оршдог.

Зуу гаруй мянган хүн амтай Дархан-Уул аймагт социализмын үед цемент, шохой, керамзит, эрдэс хөвөн, силикат, тоосго үйлдвэрлэх барилгын материалын олон үйлдвэрүүд баригдсанаас одоогийн байдлаар зөвхөн “Эрэл” цементийн үйлдвэр, “Силикат” ХК-ний шохойн үйлдвэр ажиллаж байна.

Эрчим хүчний үйлдвэрүүдээс Дарханы дулааны цахилгаан станц, Цахилгаан шугам сүлжээ, Шарын голын нүүрсний уурхай, хөнгөн хүнсний үйлдвэрээс Нэхий эдлэлийн үйлдвэр, Мах комбинат, Хүнсний комбинат, Гурил тэжээлийн үйлдвэр, мөн туунчлэн УБТЗ-н Дархан өртөө, Улаанбаатар-Дарханыг холбосон авто зам, холбоо, сургууль, цэцэрлэг, банк санхүүгийн олон арван байгууллагууд зах зээлийн өнөөгийн үед эрч хүчээ аван ажиллаж байна. Ийм учраас Асгат уулын шохойн чулууны орд газар нь нийгэм эдийн засгийн хөгжлийн таатай орчин бүрдсэн зах зээлтэйгээ ойрхон, дэд бүтэц сайн хөгжсөн нутагт оршдог.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

Төслийн тодорхойлолт, технологийн шийдэл, байгаль орчны төлөв байдлын суурь үнэлгээ, экспертүүдийн газар дээр нь очиж хийсэн судалгаа зэрэгт тулгуурлаж “СИ БИ ЗИ” ХХК-ийн шохойн чулуу олборлох үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлын болзошгүй болон голлох нөлөөллийн үнэлгээг хийв. Ингэхдээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол улсын хууль, Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас боловсруулсан аргачлал, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос гаргасан магадлан жагсаах болон матрицын арга, Баттелл системийн үнэлгээ зэргийг ашиглав.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь байгаль орчинд болон нийгэм, эдийн засагт хэрхэн нөлөөлөх, эдгээр нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, түүний эрчимшил зэргийг тодруулахын тулд байгаль орчны төлөв байдлын үнэлгээний ажилд магадлан жагсаах аргыг (checklist) өргөн ашигладаг байна. Энэ талаар Дэлхийн банк, НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комиссоос боловсруулсан аргачлалуудад тодорхой дурдсан байна. Гэвч Монгол орны экосистемийн өвөрмөц нөхцөл, үйлдвэрлэлийн онцлог зэргийг харгалзан энэхүү жагсаалтыг ашигласан болно.

Шохойн чулууны ордын байгаль орчны төлөв байдлын үнэлгээнд доорх магадлан жагсаах аргыг хэрэглэсэн дүнг доор өгүүлэв. (Хүснэгт 9).

Хүснэгт 8. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

| Байгаль орчны үзүүлэлт                     | Шууд | Шууд бус | Өөрөө зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
|--------------------------------------------|------|----------|---------------------|------------------|---------------|----------------|--------------------|--------|------------|------------|
| <b>1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт</b> |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Гадаргын усны урсацын өөрчлөлт             |      | х        |                     | х                |               |                | х                  |        |            | х          |
| Гадаргын усны чанарын өөрчлөлт             |      | х        |                     | х                |               |                | х                  |        | х          |            |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт                  | х    |          |                     |                  | х             |                | х                  | х      |            |            |
| Хөрсний элэгдэл, эвдрэл                    | х    |          |                     |                  | х             |                | х                  | х      |            |            |
| Геологийн тогтоцын өөрчлөлт                | х    |          |                     |                  | х             |                | х                  | х      |            |            |
| Зэрлэг амьтдын орон зай                    | х    |          |                     | х                |               |                | х                  |        |            | х          |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт             |      | х        | х                   | х                |               |                |                    |        |            | х          |
| <b>2. Байгалийн нөөц, ашиглалт</b>         |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Газрын гадаргын нөөц баялаг                | х    |          |                     |                  | х             |                | х                  |        |            |            |
| Бэлчээрийн байдал                          |      | х        |                     | х                |               | х              |                    |        |            | х          |
| Эрдэс түүхий эдийн нөөц                    | х    |          |                     |                  | х             |                | х                  | х      |            |            |
| <b>3. Байгаль, орчны өөрчлөлт</b>          |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Ундны усны чанар, хэмжээ                   |      | х        |                     | х                |               |                | х                  |        |            | х          |
| Урсгал усны хэрэгцээ                       |      |          |                     |                  |               |                |                    |        |            |            |
| Агаарын бохирдол                           | х    |          |                     | х                |               |                | х                  |        |            | х          |

|                                                                                                 |    |   |   |    |   |   |    |   |   |    |
|-------------------------------------------------------------------------------------------------|----|---|---|----|---|---|----|---|---|----|
| Хөрсний эвдрэл, бохирдол                                                                        | х  |   |   | х  |   |   | х  |   |   | х  |
| Дуу чимээ, шуугианы<br>нөлөөлөл                                                                 | х  |   |   | х  |   |   | х  |   |   | х  |
| <b>4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор</b>      |    |   |   |    |   |   |    |   |   |    |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө<br>төрх өөрчлөгдөх                                                    | х  |   |   |    | х |   | х  |   | х |    |
| Ландшафтын хэлбэр, өнгө<br>өөрчлөгдөх                                                           | х  |   |   |    | х |   | х  |   | х |    |
| Тусгай хамгаалалттай<br>газар нутагт нөлөөлөх                                                   |    |   |   |    |   |   |    |   |   |    |
| Түүх соёлын дурсгалт<br>зүйлд нөлөөлөх                                                          |    |   |   |    |   |   |    |   |   |    |
| Археологи,<br>палеонтологийн олдворт<br>нөлөөлөх                                                |    |   |   |    |   |   |    |   |   |    |
| <b>5. Эдийн засаг, нийгмийн асуудал</b>                                                         |    |   |   |    |   |   |    |   |   |    |
| Хувийн өмчийн болон<br>татварын орлого<br>өөрчлөгдөх                                            | х  |   |   | х  |   |   |    |   | х |    |
| Орон нутгийн орлого<br>нэмэгдэх                                                                 | х  |   |   | х  |   |   | х  | х |   |    |
| Ядуурлыг бууруулахад<br>дэмжлэг болох                                                           | х  |   |   | х  |   |   |    |   | х |    |
| Ажлын байр нэмэгдэх                                                                             | х  |   |   |    |   |   |    |   |   | х  |
| Улирлын чанартай эрэлт<br>хэрэгцээ нэмэгдэх                                                     | х  |   |   | х  |   |   |    |   | х |    |
| Хүн амын эрүүл мэндэд<br>нөлөөлөх                                                               |    | х |   | х  |   |   |    |   |   | х  |
| <b>6. Бусад нөлөөлөл</b>                                                                        |    |   |   |    |   |   |    |   |   |    |
| Шороон зам харилцаа,<br>уурхайн машин<br>механизмын хөдөлгөөн<br>шилжилтээс болж хөрс<br>эвдрэх | х  |   |   |    | х |   | х  |   | х |    |
| Ахуйн бохир ус, нефтийн<br>бүтээгдэхүүн хөрсөнд<br>нэвчиж, хөрс, ба грунтын<br>усыг бохирдуулах | х  |   |   |    |   |   | х  |   |   | х  |
| Ахуйн хаягдал, хогийн<br>ариутгал муугаас эвгүй<br>үнэр гарах, шавьж үржих                      | х  |   |   | х  |   | х |    |   |   | х  |
| Хүчтэй салхи, уруйн үер                                                                         | х  |   |   | х  |   |   | х  | х |   |    |
| Дүн                                                                                             | 20 | 6 | 1 | 16 | 8 | 2 | 18 | 6 | 7 | 12 |

**Болзошгүй шууд нөлөөлөл:**

Хөрс хуулах, шохойн чулуу олборлох, зам гаргах үед хөрсний эвдрэл үүсэх, түүнд өртсөн ургамлан нөмрөг, биологийн төрөл зүйл устгах, суларсан хөрс шорооноос агаарын бохирдол үүсэх

- ✓ Байгалийн хүчин зүйлсээс шалтгаалан хүчтэй салхи, газар хөдлөл, үер зэрэг байгалийн гамшиг бий болох
- ✓ Усны нөөц тодорхой хэмжээгээр хомсдох
- ✓ Ажиллагсдын хайнга ажиллагаанаас гал түймэр гарах
- ✓ Хатуу, шингэн хаягдлыг тогтоосон хугацаанд зайлуулаагүйгээс орчин бохирдох
- ✓ Шатах, тослох материал асгарснаас орчин бохирдох
- ✓ Шатах, тослох материалын ууршилтаас агаарын бохирдол үүсэх
- ✓ Уурхайн машин техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэх

### **Болзошгүй шууд бус нөлөөлөл**

- ✓ Шохойн чулуу олборлолтоос бичил биетэн, биологийн төрөл зүйлд нөлөөлөх
- ✓ Хөрс хуулалт болон олборлолтоос шалтгаалан хөрсний үржил шим алдагдах

### **Урт хугацааны нөлөөлөл**

- ✓ Шохойн чулуу олборлолтоос үүдэн гарах урт хугацааны нөлөөлөл нь хөрсний эвдрэл, ургамалан нөмрөг устах зэрэг асуудал болно. Иймд нөхөн сэргээлтийн ажлыг чанартай хийх шаардлагатай.

### **Богино хугацааны нөлөөлөл:**

Орчны дуу чимээ ихсэх, агаарын бохирдол түр хугацаагаар үүсэх, ус хэрэглээнээс цэвэр усны нөөц богино хугацаанд өөрчлөгдөх зэрэг нөлөөлөл үүнд хамаарна.

### **Эрчимтэй нөлөөлөл:**

Нарийвчилсан үнэлгээний үр дүнгээс үзэхэд шохойн чулуу олборлолтын үйл ажиллагаанаас байгаль орчинд эрчимтэй сөрөг нөлөөлөл үзүүлэх үйл ажиллагаа нь шохойн чулууны орд газрын хөрсний эвдрэл, агаарын бохирдол юм.

### **Төслийн байршил шийдэлтэй холбоотой болзошгүй нөлөөлөл:**

“СИ БИ ЗИ” ХХК-ийн шохойн чулуу олборлох үйл ажиллагааны үед уг уурхайн байршил, техник-технологийн шийдэл болон төсөл хэрэгжих үеийн байгаль орчны асуудлыг тусад нь авч үзэн магадлах жагсаалтанд түүний нөлөөллийн үр дагаврыг ”бага” “дунд” ”их” гэсэн утгуудын аль тохирохыг “х” гэж бөглөв.

Монгол орны нөхцөлд ил аргаар байгалийн эрдэс баялагийг олборлодог үйлдвэрүүдийн хувьд онц аюултай хүчтэй салхи, уруйн үер (хүчтэй аадар борооны дараах) зэрэг аюулт үзэгдэлд нэрвэгдэж болох талтай.

Шохойн чулуу олборлох үйл ажиллагаа нь хүн ам төвлөрсөн Дархан хотын захад, урсгал уснаас хол тул түүний байршлаас шууд шалтгаалах сөрөг нөлөөлөл төдий л их биш юм.

*Хүснэгт 9. Байгаль орчинд үзүүлэх болзошгүй нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь*

| Байгаль орчны асуудал                                                                                                                                                                                             | Нөлөөлөл байхгүй | Гол үр дагавар |      |    |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|------------------|----------------|------|----|
|                                                                                                                                                                                                                   |                  | бага           | дунд | их |
| 1. Төслийн байршилтай холбоотой байгаль орчны асуудал                                                                                                                                                             |                  |                |      |    |
| Голын гольдролыг эвдэж, өөрчлөх                                                                                                                                                                                   | х                |                |      |    |
| Хүн амыг нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой асуудал                                                                                                                                                                   | х                |                |      |    |
| Ой модыг огтлох, гэмтээх асуудал                                                                                                                                                                                  | х                |                |      |    |
| Түүх, дурсгалт газар, археологи-палеонтологийн олдворт газрыг эвдэхэд хүрэх                                                                                                                                       | х                |                |      |    |
| Усан хангамж, ус хэрэглээний асуудлаар өөр байгууллагын үйл ажиллагаатай зөрчилдөх                                                                                                                                | х                |                |      |    |
| Булаг шандны усны горимд өөрчлөлт орох ба хатах, ширгэж үгүй болох аюултай эсэх                                                                                                                                   | х                |                |      |    |
| 2. Төслийн шийдэл, төлөвлөгөөтэй холбоотой байгаль орчны асуудал                                                                                                                                                  |                  |                |      |    |
| Үйл ажиллагааны болон ашиглалтын чанар нь тухайн орон нутагт нийцтэй эсэх, түүхий эдийг олзворлох, боловсруулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх болон орчны бохирдлын хяналтад сонгосон төхөөрөмж нь хир зэрэг зохимжтой |                  |                | х    |    |
| Үйлдвэрлэлийн осол, мэргэжлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон ажилтнуудыг тэсэлгээ, хорт хий, гал түймрээс хамгаалах асуудал хир зэрэг төлөвлөгдсөн                                                            |                  |                | х    |    |

|                                                                                                                                                                                                                                                            |   |   |   |   |
